

**APU COMPANY**

Absolute. Pure. Unique.



**АПУ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН

Ж.БАТЗОЛБОО

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:

АПУ ХК – ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.ЭРДЭНЭБИЛЭГ

ТОГТОЛЦОО ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ж.Нэргүй

**2022 он**

## АГУУЛГА

<b>НЭГ. АПУ ХК – ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	4
1.1 Төслийн товч танилцуулга .....	4
1.2 АПУ ХК – ийн Байгаль орчны менежментийн тогтолцооны танилцуулга .....	6
1.3 Орчны хяналт шинжилгээ.....	7
1.3.1 Хөрсний бохирдол .....	7
1.3.2 Орчны агаарын чанар .....	8
1.3.3 Усны чанар.....	9
<b>ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b> .....	10
2.1 Болзошгүй нөлөөллийн үнэлгээ .....	10
<b>ГУРАВ. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	13
3.1 Удирлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	15
3.2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	20
3.3 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	24
3.4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	27
3.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....	31
<b>ДӨРӨВ. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ГҮЙЦЭТГЭХЭД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ЗАДАРГАА БҮДҮҮВЧ</b> .....	33
<b>ТАВ. ДҮГНЭЛТ</b> .....	36

---

Зураг 1. Үйлдвэрийн байршил.....	5
Зураг 2. Үйлдвэрийн зохион байгуулалтын бүдүүвч.....	5
Зураг 3. Үйлдвэр, алба нэгжүүд дэхь байгаль орчны дэд багийн гишүүд .....	6
Зураг 4. Хөрсний дээж авсан цэгүүд	Зураг 5. Хөрсний дээжнүүд .....
Зураг 6. БО-ы удирдлагын дэд бүтэц.....	15
Зураг 7. Үйлдвэр орчмын ногоон байгууламж .....	22
Зураг 8. 1080 мод тарих аян .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Зураг 11. Аюултай хог хаягдлын сав баглаа боодлын ачилт .....	30
Зураг 12. Шингэн шаар ачих хэсэг.....	
Зураг 13. Прессэрийн дараах КГ .....	
Хүснэгт 1. Хөрсний дээж авсан тэмдэглэл.....	7
Хүснэгт 2. Хөрсний хүнд металлын агууламж .....	8
Хүснэгт 3. Хөрсний хүнд металлын агууламж (үргэлжлэл).....	8
Хүснэгт 4. Гадна агаарын чанарын хэмжилтийн дүн.....	9
Хүснэгт 5. Гарч буй хаягдал усны чанарын шинжилгээ .....	9
Хүснэгт 6. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим.....	11
Хүснэгт 7. Нөлөөллийн үнэлгээний матриц .....	12

## НЭГ. АПУ ХК – ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


### 1.1 Төслийн товч танилцуулга

<b>Төслийн нэр:</b>	Архи, пиво, ус ундааны үйлдвэрлэл
<b>Төсөл хэрэгжүүлэгч:</b>	АПУ ХК
<b>Хэлбэр:</b>	Нээлттэй хувьцаат компани
<b>Хувьцаа эзэмшигчдийн тоо:</b>	4870
<b>Нийт хувьцааны тоо ширхэг:</b>	1.604.181.553 ширхэг
<b>Улсын бүртгэлийн дугаар:</b>	9010001005
<b>Регистрийн дугаар:</b>	2702673
<b>Холбоо барих утас:</b>	91110409
<b>Байршил:</b>	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19 – р хороо, Чингисийн өргөн чөлөө 14, АПУ ХК - ний байр
<b>Төслийн зорилго:</b>	Орчин үеийн дэвшилтэт техник, технологи ашиглан үндэсний болон олон улсын стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн хэрэглэгчдийг хангах, импортын бүтээгдэхүүнийг орлож, дотоодын зах зээлийг дотоодын бүтээгдэхүүнээр хангахад чиглэсэн Монгол улсын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд гаргах, үйлдвэрлэлд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх зэрэг зорилго, ач холбогдолтой.
<b>Үйл ажиллагааны чиглэл</b>	Архины үйлдвэрлэл Спиртийн үйлдвэрлэл Пивоны үйлдвэрлэл Ус, ундаа, жүүс үйлдвэрлэл Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл Гадаад худалдаа Хүнсний бөөний төв болон жижиглэнгийн худалдаа Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
<b>Ажиллах хүч:</b>	854
<b>Ус, дулаан, цахилгаан, уурын хангамж</b>	Төвийн шугам сүлжээнд холбогдсон.
<b>Татвар төлөлт:</b>	МУ нэгдсэн төсвийн орлого 1.6% буюу 129 тэрбум/ төг Онцгой албан татварын орлого 18.3% буюу 95 тэрбум/төг НӨАТ орлого 1.3% буюу 20 тэрбум/төг
<b>Дотоодын зах зээлд бүтээгдэхүүний эзлэх хувь</b>	Архины зах зээлийн 49-51% Пивоны зах зээлийн 61-63% Хийжүүлсэн ундааны зах зээлийн 3% Цэвэр усны зах зээлийн 5-6%-ийг тус тус хангаж байна.



Зураг 1. Үйлдвэрийн байршил

АПУ ХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 19 – р хорооны нутаг дэвсгэр Чингисийн өргөн чөлөөнд байрладаг ба ус, ундаа, шар айраг, архи зэрэг шингэн хүнсний үйлдвэрлэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Үйлдвэрийн бүтэц зохион байгуулалтын хувьд АПУ ХК нь Архины үйлдвэр, Пивоны үйлдвэр, Лонх угаах үйлдвэр (архи, пивоны лонх угаах хэсэг), Савлах үйлдвэр (ус, ундаа, ПЭТ, лонх, лаазанд савлах хэсэг), бэлэн бүтээгдэхүүн болон түүхий эд, туслах материалын агуулах гэсэн үйлдвэрийн хэсгүүдтэй.




Зураг 2. Үйлдвэрийн зохион байгуулалтын бүдүүвч

## 1.2 АПУ ХК – ийн Байгаль орчны менежментийн тогтолцооны танилцуулга

АПУ хувьцаат компанийн бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь ‘Тогтвортой хөгжил’-ийн үндсэн суурь зарчим болох НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИН тэнцвэртэй хөгжлийг ханган нийгэм, эдийн засаг, хүн баялагт үнэ цэн бүтээхэд чиглэн ажилладаг билээ. Байгаль орчин тогтвортой хөгжлийн стратеги нь АПУ компанийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бүхий л үйлдвэр үйл ажиллагааны туршид байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, аюултай материал, ус, эрчим хүч болон бусад байгалийн нөөцийн хэрэглээг хэмнэх, үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зэрэг зарчимуудыг баримтлан ажилласаар байна. Иймд 2022 оны тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд “Илүү сайхан дэлхийг цогцлооё” уриан доор үйлдвэрлэл үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийг хэрэгжүүлэн ажиллалаа. Байгаль орчин тогтвортой хөгжлийн хүрээнд бид 2022 онд байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах, хэрэгжүүлэлтийг нэмэгдүүлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах бий болгох зэрэг үндсэн зорилтын хүрээнд ажилласан билээ.

1. Байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах, тогтвортой хөгжүүлэх ажлын хүрээнд нийт үйлдвэр нэгж хэсгүүдэд байгаль орчны дэд багуудыг шинэчлэн байгуулж ажилчид гишүүдийн оролцоог нэмэгдүүлэн ISO 14001 БОМТ –ны хэрэгжилтийг хангуулахад хамтран ажилладаг боллоо.



Зураг 3. Үйлдвэр, алба нэгжүүд дэхь байгаль орчны дэд багийн гишүүд



Үүний зэрэгцээ эрчим хүчний баг байгуулагдан эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөр болон эрчим хүчний аудитыг хийлгэсэн билээ.

2. Хог хаягдлын менежментийн хүрээнд хог хаягдлын 3R стратегийг үйлдвэр нэгж хэсгүүдэд хэрэгжүүлэн хог хаягдлын цэгүүдийг 5S зарчмын дагуу сайжруулан хог хаягдлын ангилан хаялтыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж нийт хог хаягдлын хэмжээгээ энэ үеийн өмнөх онтой харьцуулахад 30% -иар бууруулж дахин боловсруулах компаниудын түншлэлээ нэмэгдүүллээ. Тухайлбал аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодлыг дахин боловсруулах үйлдвэр Түмэн Эгшиг ХХК болон хаягдал шилээ Шинэ шил ХХК, хаягдал гялгах уутаа Мултипак ХХК зэрэг компаниудтай хамтран ажиллаж дахивар хаягдлуудаа тус тус нийлүүлсээр байна.

### 1.3 Орчны хяналт шинжилгээ

#### 1.3.1 Хөрсний бохирдол

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны 06 -р сард үйлдвэрийн гадна талбайгаас хөрсний дээжийг авч, “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ний Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.



Зураг 4. Хөрсний дээж авсан цэгүүд

Дээж	№1	№2	№3
Сорьц авсан гүн	0 – 10 см	0 – 10 см	Өнгөн хэсэг
Хөрсний өнгө	Хүрэн	Хар хүрэн	Цайвар хүрэн
Сорьц авсан цэг	Үйлдвэрийн ногоон байгууламж орчим	Үйлдвэрийн хашаа	Ауруг авто зогсоолын орчим
Сорьц авсан цэгийн солбицол	47° 53' 56" N 106° 54' 18" E	47° 53' 48" N 106° 54' 18" E	47° 53' 49" N 106° 54' 21" E

Хүснэгт 1. Хөрсний дээж авсан тэмдэглэл

№	ЛАБОРАТОР ИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	Химийн үзүүлэлтүүд, %					ЭЛЕМЕНТ, экв/100г				
				pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялз маг	CaC O <sub>3</sub>	Ca <sup>+2</sup>	Mg <sup>+2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O	NO <sub>3</sub> , мг/100г
1	Л-22/06-16/1	APU-1	Ногоон байгууламж орчим	8.04	0.145	0.362	2.48	0	15	6	4.1	70	0.92
2	Л-22/06-12/2	APU-2	Үйлдвэрийн хашаа	7.97	0.301	0.752	3.97	0.64	17	7	5	3	1.27
3	Л-22/05-16/3	APU-3	Ауруг зогсоол орчим	8.19	0.042	0.106	4.32	0	23	7	4.5	16	0.74
<b>MNS6824:2020</b>				-	-	-	-	-	-	-	-	-	-

Хүснэгт 2. Хөрсний агро химийн шинжилгээний харуу

ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг					
		Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
APU-1	ногоон байгууламж орчим	6.1	29.6	0.0	77.6	12.3	13.1
APU-2	Үйлдвэрийн хашаа	18.2	27.3	0.0	74.4	27.1	5.2
APU-3	Ауруг зогсоол орчим	24.3	25	0.0	64.5	11.2	20.5
<b>Зөвшөөрөгдөх дээх хэмжээ MNS5850:2019</b>		<b>60.00</b>	<b>50.0</b>	<b>1</b>	<b>100</b>	<b>60</b>	<b>60</b>

Хүснэгт 3. Хөрсний хүнд металлын агууламж (үргэлжлэл)

Шинжилгээний үр дүнгээс харахад бүх үзүүлэлт нь MNS 5850 : 2008 стандарттай харьцуулахад хөрсөнд агуулагдах хүнд металлын хэмжээ стандарт хэмжээнээс даваагүй үзүүлэлттэй гарсан байна.

### 1.3.2 Орчны агаарын чанар

2022 оны 10-р сард нэрийн архины авдарлагааны цэг, шинэ пивоны үйлдвэрийн исгэлтийн танкны ойролцоо, савлах үйлдвэрийн Лет2 савлах машины ойролцоо, АПУ үйлдвэрийн хойд талын авто зогсоол гэсэн 5 - н цэгээс азотын давхар исэл, хүхэрлэг хий, нийт тоосны хэмжилтийг хийж “Ногоон Титэм” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад үйлдвэр гадна агаар дахь NO<sub>2</sub>, SO<sub>2</sub> нийт тоосны агууламж “Агаарын чанарын стандарт” MNS 4585:2016 дотоод орчны агаар Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ажлын байрны орчин MNS 4990:2000 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.





Зураг 5. Агаарын чанарын шинжилгээ

№	Сорьц авсан цэг	Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> ), мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл (NO <sub>2</sub> ), мг/м <sup>3</sup>	Нийт тоосны агууламж, мг/м <sup>3</sup>
<b>Агаарын чанарын стандарт MNS 4585:2016</b>		<b>0.450</b>	<b>0.200</b>	<b>0.500</b>
1	Савлах үйлдвэрийн Лет2-ийн савлах машины ойролцоо	36.80 мг/м <sup>3</sup>	27.91 мг/м <sup>3</sup>	-
2	Нэрийн архины үйлдвэр, авдарлагааны хэсэг	<20мкг/м <sup>3</sup>	10.77 мг/м <sup>3</sup>	-
3	Шинэ пивоны үйлдвэр хөрөнгөний танкны ойролцоо	384.88 мг/м <sup>3</sup>	<3 мг/м <sup>3</sup>	-
4	Апу үйлдвэр, хойд талын авто зогсоол	-	-	<0.01
5	Апу үйлдвэр, урд талын авто зогсоол	-	-	0.03
<b>Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ажлын байрны орчин MNS 4990 : 2000</b>		-	-	10 мг/м <sup>3</sup>

Хүснэгт 4. Гадна агаарын чанарын хэмжилтийн дүн

### 1.3.3 Усны чанар

Төвлөрсөн төвийн шугамын усны дээжинд АПУ ХК-ийн өөрийн итгэмжлэгдсэн төв лабораторид сард бүр чанарын шинжилгээ хийдэг. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны 07 сарын 19-ний өдөр үйлдвэрийн хаягдал уснаас (Б-675) дээж аван Ус сувгийн удирдах газар усны төв лабораторид шинжлүүлсэн ба дараах хүснэгтэд сорилтын тайланг харуулав.

Шинжилгээний аргачлал	Шинжилсэн үзүүлэлт	Нэгж	ЗДА	Б-341	ЗДА-аас хэтэрсэн
MNS ISO 10523 : 2001	Усан орчин	-	6-9	7.88	-
MNS ISO 11923 : 2001	Умбуур бодис	мг/л	400	172	-
MNS ISO 6060 : 2001	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч	мг/л	800	751	-
MNS ISO 1097 : 1970	Аммони	мг/л	15	1.425	-

Хүснэгт 5. Гарч буй хаягдал усны чанарын шинжилгээ

Сорьцын ерөнхий байдал нь цайвар цагаан саарал өнгөтэй, үнэртэй, механик хольц бага тунасан дээд ус булингартай байсан. Усны чанарын шинжилгээний үр дүнгээс харахад бүх үзүүлэлт нь MNS 6561 : 2015 ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны стандартад заагдсан зөвшөөрөх дээд агууламжаас хэтэрсэн үзүүлэлтгүй гарсан байна.

## ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

### 2.1 Болзошгүй нөлөөллийн үнэлгээ

“Цагаан Уулын Оргил” ХХК нь 2019 онд АПУ ХК - ийн архи, пиво, савлах үйлдвэрийн төслийн баримт бичиг, зураг төсөл, бүртгэл тэмдэглэл, үйлдвэрийн орчинд хийсэн хэмжилтийн үр дүн, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол доройтлын түвшин, химийн бодисын эрсдлийн үнэлгээ зэрэгт үндэслэн үйлдвэрийг 4 хэсэгт хуваан, хэсэг тус бүрт үнэлгээ хийснийг энэ бүлэгт нэгтгэн магадлан жагсаах буюу хяналтын болон асуулгын хуудасны арга, математик статистикийн аргуудыг ашиглан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон.

		Хэлбэр		Хугацаа			Чиглэл		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Урт	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд	Сул
<b>1. Байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны чанарын асуудал</b>											
1	Уур амьсгалын өөрчлөлт		-			-		-			-
2	Усны нөөц ашиглах	-				-		-		-	
3	Газрын доорхи усны нөөц хомсдох	-				-		-			-
4	Эрчим хүч хэрэглэх	х				х		х			Х
5	Ургамлын нөмрөгт нөлөөлөх	-			-			-			-
6	Гадаргын усны чанарт нөлөөлөх		-			-		-			-
7	Агаарын чанарт нөлөөлөх		-			-		-			-
8	Хөрсний бохирдол үүсэх	-				-		-			-
9	Химийн бодис хөрсөнд нэвчиж, хөрс ба гүний усыг бохирдуулах		-		-			-			-
10	Дуу чимээ, доргио чичиргээний нөлөө үүсэх	-				-		-			-
11	Хатуу хог хаягдал үүсэх	-				-		-		-	
12	Шингэн хог хаягдал үүсэх	-				-		-		-	
13	Химийн бодисын хортой, аюултай хог хаягдал үүсэх	-				-		-			-
<b>2. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>											
14	Нийгэм, эдийн засагт эерэгээр нөлөөлөх /бүтээгдэхүүн үйлдвэрлэл өсөх/	+				+		+			+
15	Байгалийн нөөц ашигласны төлбөр, хариуцлага	+				+		+			+
16	Харьяа орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+
17	Харьяа орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	+				+		+			+

18	Нийгмийн хариуцлага, соёлд нөлөөлөх	+				+	+			+	
19	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
<b>3. Бусад нөлөөлөл</b>											
20	Үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх		-		-		-				-
21	Хүчтэй салхи, түймэр, аюул осол		-		-		-			-	
Дүн, тоогоор		16	6	-	4	17	8	13	-	10	11
Дүн, хувиар		76	24	-	19	81	38	62	-	48	52

Хүснэгт 6. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

(+) Эерэг нөлөөтэй, (-) Сөрөг нөлөөтэй, (х) Ямар нэг эерэг, сөрөг нөлөөгүй

### Нөлөөллийн үр дүн:

Төслөөс байгаль орчин, нийгэм, эдийн засагт шууд байдлаар үзүүлэх нөлөөллийн 31.2% нь ямар нэгэн эерэг, сөрөг нөлөөгүй, 18.7% нь эерэг, 50% нь сөрөг нөлөөлөлтэй байна. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад усны нөөц, химийн бодис, бүтээгдэхүүн ашиглах, хатуу шингэн хог хаягдал, дуу чимээ, доргио чичиргээ үүсэх зэрэг нь сул эрчимтэйгээр урт хугацаанд, харин гэнэтийн осол аваар, эрсдэл, гал түймэр, үер, хүчтэй салхи зэрэг нь дунд эрчимтэйгээр богино хугацаанд буцалтгүйгээр шууд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн хувьд “АПУ” ХК нь жилд ойролцоогоор Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 1.6% буюу 129 тэрбум.төг, Онцгой албан татварын орлого 18.3% буюу 95 тэрбум.төг, НӨАТ орлого 1.3% буюу 20тэрбум.төг, Гаалийн татварт 3.7 тэрбум.төг, ААНОАТ-т 4.8 тэрбум.төг, бусад татварт 4.9 тэрбум төгрөгийг дангаараа бүрдүүлдэг тул дунд эрчимтэйгээр урт хугацаанд шууд хэлбэрээр эерэгээр буцаж нөлөөлнө.

Харин орон нутагт физик өөрчлөлт гарах, усны нөөц хомсдох, байгалийн дагалдах нөөц баялаг хомсдох, орчны агаарын чанар зэрэгт ямар нэгэн эерэг, сөрөг нөлөө үзүүлэхгүй

Экосистемийн бүрэлдэхүүн хэсэг			Нөлөөллийн хүчин зүйлүүд								
			Архины үйлдвэр	Пивоны үйлдвэр	Савлах үйлдвэр	Лонх угаах үйлдвэр	Түүхий эдийн агуулах	Бэлэн бүтээгдэхүүний агуулах	Лаборатори	Хог хаягдлын цэг	
			A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	
Агаар	Агаарт бохирдуулагч бодис ялгаруулах	B1	10	9	10	10	10	10	10	10	9
	Дуу чимээ, доргио чичиргээ үүсгэх	B2	7	10	7	9	10	10	10	10	10
	Агаарт үнэрийн бохирдол үүсгэх	B3	10	8	10	10	10	10	10	10	8
	Цахилгаан соронзон цацраг үүсгэх	B4	10	10	8	10	10	10	10	10	10
Ус	Усны нөөц ашиглах	B5	8	8	8	6	10	10	10	10	10
	Усны нөөцийн хомсдол үүсгэх	B6	9	9	9	8	10	10	10	10	10

	Усны бохирдол үүсгэх	B7	8	8	8	6	10	10	10	10
Хөрс	Хөрсөн бүрхэвч эвдрэх	B8	10	10	10	10	8	8	10	8
	Хөрс бохирдуулах	B9	10	10	10	10	8	10	10	8
	Хөрс доройтох, цөлжих	B10	10	10	10	10	10	10	10	10
	Ургамлан нөмрөг, ой мод өртөх	B11	10	10	10	10	9	10	10	9
Ургамал	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх	B12	9	9	10	10	10	10	10	10
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах	B13	10	10	10	10	10	10	10	10
Амьтан	Ховор, нэн ховор амьтан өртөх	B14	10	10	10	10	10	10	10	10
	<b>Дүн</b>		131	131	130	129	135	138	137	132
	Сөрөг нөлөөгүй 9-10	Хамгийн их анхаарал татаж буй асуудлууд: Дуу чимээ Усны бохирдол Усны нөөц ашиглах								
	Сөрөг нөлөө бага 7-8									
	Сөрөг нөлөө дунд 5-6									
	Сөрөг нөлөө их 3-4									
	Сөрөг нөлөө маш их 1-2									

Хүснэгт 7. Нөлөөллийн үнэлгээний матриц

Үр дүн: Байесын критээрээр үнэлсэн нөлөөллийн матрицын үр дүнг нөлөөллийн хүчин зүйлсээр дараалуулбал  $A4 > A3 > A2 > A1 > A9 > A5 > A8 > A7$  гэсэн дарааллаар үнэлгээний жин эзэлж байна. Эндээс харахад хамгийн их анхаарал татаж буй асуудлууд болох үүсэх хатуу хог хаягдлын хэмжээ, ашиглаж байгаа цэвэр усны хэмжээ, хаягдал усны чанар, дуу чимээний үзүүлэлтүүдээр хамгийн бага оноо авч байгаа үйлдвэрийн хэсгүүдэд лонх угаах, савлах, архи-пивоны үйлдвэрүүд орж байна. Харин лаборатори болон аюултай хог хаягдлын цэг зэрэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд болзошгүй эрсдэлийн эх үүсвэр болох боловч экосистемд нийтэд нь нөлөөлөх байдал бага байна.

## ГУРАВ. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бидний зорилт: Хүний эрхийг дээдэлж тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэв.

АПУ компанид хүний эрхийн сөрөг нөлөөллийн эрсдэл бий эсэх, хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тайлагнах зорилгоор “Хүний эрхийн хянан магадалгаа”-г MDS Khanlex хуулийн фирм, IWFCI Mongolia ТББ зэрэг байгууллагуудтай хамтран хийлээ.



Уг судалгааг хийхдээ компанийн дотоод батлагдсан дүрэм журам нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц: “Хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” зэрэг нийцлийг хянаж, мөрдсөний дагуу явууллаа. Мөн цаашлаад компанийн дотоодын ажилтнуудаас бараа бүтээгдэхүүн ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалт, маркетинг, зар сурталчилгаа, хөдөлмөрийн харилцаа, гэсэн хэсэгт хуваан судалгааг авсан бөгөөд үүн дээр үндэслэн зөрчил илрүүлэх, сайжруулах процесс санал зөвлөмжийн тодорхойлоо.

АПУ хувьцаат компанийн бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь “Тогтвортой хөгжил”-ийн үндсэн суурь зарчим болох НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИН тэнцвэртэй хөгжлийг ханган нийгэм, эдийн засаг, хүн баялагт үнэ цэн бүтээхэд чиглэн ажилладаг билээ. Байгаль орчин тогтвортой хөгжлийн стратеги нь АПУ компанийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бүхий л үйлдвэр үйл ажиллагааны туршид байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, аюултай материал, ус, эрчим хүч болон бусад байгалийн нөөцийн хэрэглээг хэмнэх, үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зэрэг зарчмуудыг баримтлан ажилласаар байна.

## Хөхүүл ээжийн булан



Хөхүүл эхчүүдэд зориулсан жишиг буланг “Mommy’s corner” нэртэйгээр АПУ Дэйри ХХК-ийн оффист байршууллаа. “Mommy’s corner”-ийг байгуулан компанид ажиллаж буй хөхүүл эхчүүдийн хэрэгцээг хангаснаар бүтээмжийг дээшлүүлж, улмаар соёл, ажлын байрны таатай орчныг бий болгож байна. Эхийн сүүгээр хооллох, ажлын байранд хөхөө саах орчныг бүрдүүлэх нь хүн амын эрүүл мэнд, ирээдүй хойч болсон үр хүүхдийн эрүүл өсөлтөд эергээр нөлөөлсөн ажил болно гэж итгэж байна. Амьдралын мөч бүрийг хамтдаа. Жич: Уг загвар төслийг UNICEF-ээс гаргасан эхчүүдэд зориулсан булан тохижуулах зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэв

## “Чи чадна- Шилээ дахин амьдруулья” төсөл

АПУ ХК нь “Чи чадна- Шилээ дахин амьдруулья” төслийн үргэлжлэл болгон шилний хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах хэрэглээний хэв маягийг бүрдүүлэх зорилгоор Чи чадна төслийг амжилттай хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд хэрэглэгч түгээгч тээвэрлэлтийн байгууллага бүхий л оролцогч талуудыг хамруулан шилийг онцгой үнээр эрүүлэн авч харилцан эдийн засгийн өгөөжийг хүртэх замаар нийт 960 гаруй агентыг төсөлд нэгтгэн шилний эргэлтийг 3 дахин нэмэгдүүлж чадлаа. Шилээ дахин амьдруулснаар түүхий эд орц найрлагад орох байгалийн нөөцийн баялгийг хэмнэх шилний импортын хамралыг багасгаж, хил гаалийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах, шил шинээр үйлдвэрлэхээс гарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зэрэг нийгэм эдийн засаг, байгаль орчинд ихээхэн өндөр ач холбогдолтой юм. Бид шингэн хүнсний салбарт тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаа, байгальд ээлтэй хариуцлагатай байх чиглэлд хамтын бодлого баримтлан ийнхүү ажиллаж байна.

Хамгийн олон шил татсан агент:  
**Б.БУРМАА**  
МОНГОЛ ДЭВГЧҮҮ  
БАНХОШУУ

НИЙТ ТАТСАН ШИЛ  
**2,323ш**

ШИЛЭЭ ҮҮШААЖ  
2 СӨЛӨН БУГААЛАМ

12 ТӨРӨГНИЙ ШИЛ ТАТАН АВСАН



### 3.1 Удирлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

АПУ ХК-ийн Байгаль орчны дэд хэсэг нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны (ХАБЭАБО) албанд харьяалагддаг ба байгалийн нөөцийн менежмент, түүний зохистой хэрэглээ, хог хягдлын менежмент, хүрээлэн буй орчинд нөлөөлж болзошгүй эрсдлийн менежмент, орчны хяналт шинжилгээ зэрэг чиглэлүүдэд үйл ажиллагаагаа явуулж Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг ханган ажиллуулах зорилттойгоор ажиллаж байна. Түүнчлэн АПУ ХК нь 2011 оноос олон улсын ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэн амжилттай хэрэгжүүлсээр байна. 2020 оны БОМТ-ий хэрэгжилтийг шалгах ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээ.

**Төлөвлөсөн арга хэмжээ 1**  
БОМТ-ний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх

**Ажлын гүйцэтгэл:** Байгаль орчны менежментийн тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд үйлдвэрийн нэгж хэсгүүдэд байгаль орчны дэд багуудыг байгуулж, багийн гишүүдийг шинэчлэн үүрэг хариуцлагыг тодорхойлсон. Үүний үр дүнд компанийн ажилчдын идэвхи оролцоог нэмэгдүүлж, ажилчдын дундах байгаль орчны мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэн, зөв дадал зуршлыг суулгаж ажилтан бүрийн оролцоотойгоор байгууллагын байгаль орчны бодлогыг хамтдаа хэрэгжүүлж байна.

Environmental Team Organization		
<p><b>Team Leader</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• БОМТ Менежмент ба байгаль орчны төлөөлөгч байгуулагч</li> <li>• ISO 14001-ийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• БОМТ-ийг агуулах үүрэг</li> <li>• Суртал ба өмчийн үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> </ul>	<p><b>Team Lead Manager</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• БОМТ Менежмент төлөөлөгч</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> </ul>	<p><b>Team Leader</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Дотоод болон гадаад харилцаа төлөөлөгч</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> </ul>
<p>Ж.Наран /System Implementation Officer/</p> <p><b>TPM Representative</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• TPM ВЭТС дундаж</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> </ul>	<p>О.Тугайн /Senior SHE Manager/</p> <p><b>Utility Member</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• ТЭГ ба байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> </ul>	<p>Б.Дэлгэрмаа /SA Manager/</p> <p><b>Utility Member</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> </ul>
<p>Ч.Түвшинбаяр /Senior TPM Engineer/</p> <p><b>Utility Member</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> </ul>	<p>Ц.Батсүх /Utility Engineer/</p> <p><b>Team Member</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• TPM менежмент</li> <li>• Байгаль орчны менежментийн системийг хэрэгжүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээний төлөө</li> </ul>	<p>Т.Анхалынбаатар /Senior Heating and Ventilation Engineer/</p>
<p>Б.Оюунгууль /Safety Protection Engineer/</p>	<p>Э.Мөнхсүх /TPM Manager/</p>	

**Төлөвлөсөн арга хэмжээ 2**

Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулж гэнэтийн осол эрсдлийн талаар сургалт

**Ажлын гүйцэтгэл:** HEINEKEN -ийн амь насаа хамгаалах амлалтууд нь манай компанид ажилладаг бүх хүмүүст хамаатай аюулгүй ажиллагааны дүрмүүд юм. Эдгээр эрсдэлийг бууруулах хөтөлбөрөөр дэмжигддэг бөгөөд ноцтой хүний амь нас алдах ослоос урьдчилан сэргийлэх түлхүүр юм. 2022 онд бид амь насаа хамгаалах 12 амлалтыг бүрэн мөрдөн ажиллаж байна.



Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэлээ. 2022 оны тухайд бид АПУ компанийн хэмжээнд гэрээт мэргэжлийн байгууллагаар бүрэн хэмжээний “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ” хийлгэж гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. Мөн эрсдэлийг даатгагч “Хаан даатгал” компанитай хамтын ажиллагааны хүрээнд Англи улсын “Tyser risk management” компанийн гадаад мэргэжилтүүдээр үйлдвэрлэл, инженерингийн тоног төхөөрөмж, байгууламжуудад эрсдэлийн үнэлгээ хийлгэж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч байна.

**Төлөвлөсөн арга хэмжээ 4**

Дэлхийн ойн өдөр” “Дэлхийн усны өдөр” “Эх дэлхийн цаг” Байгаль орчны тэмдэглэлт өдөрлөг 2022

**Ажлын гүйцэтгэл:** АПУ тогтвортой хөгжил ХАБЭАБО хамтран байгаль орны салбарын 03 дугаар сард тэмдэглэлт өдрүүд болох “Дэлхийн ойн өдөр” “Дэлхийн усны өдөр” “Эх дэлхийн цаг” болон дотоод сүлжээгээр дамжуулан ажилчдад таниулан сурталчлах, дотоод сургалт зохион байгууллаа.



2022 оны хувьд хог хаягдлын менежментийг сайжруулах бодлогод илүүтэй төвлөрч нийт ажилчдын хог хаягдлын талаарх ойлголт, ангилан хаялтын тухай мэдлэгийг сайжруулахыг зорин дотоод болон хамтрагч байгууллагуудтайгаа (Ойм ногоон урлаг ХХК, Шинэ Шил ХХК, Өнгө Нэм ТББ, “Шамбала 2056” Эко Орчин ХХК, “Грийн солар энерги” ХХК, Мултипак ХХК гэх мэт) үүсвэрээс хог хаягдалын менежментийн талаарх, байгаль орчны тэмдэглэлт өдөрлөгийн 3-н өдрийн турш амжилттай зохион байгуулж чадлаа.



## Хамтрагч байгууллагууд

### Төлөвлөсөн арга хэмжээ 5

Хог хаягдлын менежментийн гэрээ сунгуулах

#### **Ажлын гүйцэтгэл:**

Хог хаягдлын менежментийн хүрээнд хамтран ажиллагч байгууллагуудтайгаа жил бүр гэрээг 1 жилийн хугацаатайгаар сунган ажилладаг билээ. Байнгын харилцагч түншлэлүүд болох Эко – орчин ХХК – тай энгийн хог хаягдлын менежментийн гэрээ, хаягдал гялгар уут шилжүүлэх гэрээг Мултипак ХХК, Түмэн эгшиг ХХК -

тай химийн бодисын сав баглаа боодлын гэрээ, Элемент ХХК -тай эмнэлгийн аюултай хог хаягдлын гэрээг харилцан тохиролцож сунган баталсан. Мөн түүнчлэн хог хаягдлын дахин боловсруулах компаниудтай хамтын ажиллагаа тэлэн гэрээ хэлэлцээрийг хийсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг хог хаягдлын менежментийн арга хэмжээний биелэлтийн хэсгээс харна уу.



**Ажлын гүйцэтгэл:** Химийн бодисын агуулахыг шинэчлэн өргөжүүлсэнтэй холбоотойгоор MNS 6458 : 2015 химийн бодисын агуулахын стандартын шаардлагуудыг хангуулан тохижуулж өргөтгөж дуусгав. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт MNS 6458 : 2015 химийн бодисын агуулахын стандартын шаардлагуудыг хангасан эсэхийг дүгнүүлэх хүсэлтээ илгээж үйлдвэр дээрх шалгалт хяналтыг хийн гүйцэтгүүлсэн. Уг ажил одоогоор дүгнэлт боловсруулах төлөв дээр явж байна.



#### Төлөвлөсөн арга хэмжээ 7

Нийгмийн хариуцлагын хүрээнд: Байгаль орчинд ээлдээ арга хэмжээ зохион байгуулах: Мод тарих аян, их цэвэрлэгээ гэх мэт

**Ажлын гүйцэтгэл:** Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусыг дэмжих “Маргаашийн Манлайлагчид” төсөл. Нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах манлайлагчдыг нээн илрүүлэх, тэдний сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 100 оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг АПУ ХК нь 2021 оноос эхлүүлэн хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд “Хүний хөгжлийн тогтвортой бодлого” -д онцгойлон анхаарч хөтөлбөрт оролцогч оюутан залуусыг нийгэмдээ эерэг хандлага түгээж бусдыг хүндлэх, ойлгох соёлыг дэлгэрүүлэх зорилготой сургалтуудад шат дараатай хамрууллаа.



Зураг 6. Маргаашийн манлайлагчид



### 1. “Тэрбум мод” төсөл

Нийслэлийн Байгаль Орчны газартай хамтран нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих ажилд АПУ ХК компани нь 1200 ширхэг шилмүүс нарс мод тарихаар Мөнхантайшир ХХК хамтран ажиллахаар гэрээг байгуулж ажиллалаа. /Хавсралтаар дэлгэргүй мэдээлэл тайлан, хамтын ажиллагааны гэрээ, албан бичгийг харна уу. /

### 2. Хүн, байгаль, хүрээлэн буй орчиндоо ээлтэй соёлыг түгээх “Соёлоор гоёно” төсөл



АПУ ХК нь нийгмийн эерэг өөрчлөлт бий болгох зорилгоор “Соёлоор Гоёно” төслийг 2021 оноос эхлүүлэн үндсэн гурван чиглэлийн хүрээнд нөлөөллийн компани ажлуудыг үе шаттайгаар ажилтай зохион байгуулсаар байна. Үүний үр дүнд байгаль эх дэлхийдээ ээлтэй амьдрах соёл, хариуцлагатай хэрэглээний соёлыг түгээн дэлгэрүүлж, язгуур өв соёлоо сурталчлан “Дэлхийд Монгол Соёлоор Гоёно” хэмээх урилан дор дэлхий 15 улс, эх орныхоо 30 гаруй цэгээс хамтдаа бий биелээгээ биелэн үндэсний соёлоороо гоёлоо. “Соёлоор Гоёно” төслийн хүрээнд

бид өнгөрсөн хугацаанд нийт 55 гаруй төрлийн контентыг олон нийтэд түгээж, бидний өөрсдийн бүтээхийг хүсдэг соёлыг түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан хамтын дуу хоолой, хүсэл тэмүүллээ уг төслөөрөө дамжуулан илэрхийлсээр байна. Энэхүү нийгэмд чигэлсэн “Соёлоор Гоёно” төсөл нь 13 дахь удаагийн соёл, урлаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын Мөнгөн Мод 2021 наадамд Шилдэг зар сурталталчилгаа төрөлд шалгарсан анхны бүтээл боллоо.

## 3.2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйлдвэрлэл үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд нөлөөлж буй болон болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

### Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

1. Орчны тоосжилт үүсэх, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх,
2. Нүүрсхүчлийн хий, хөргөлтийн бодис агаарт алдагдах, тэсэрч дэлбэрэхээс сэргийлэх,
3. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт түгээмэл тархалттай бохирдуулагч бодис (CO, NOx, SO2) ялгарах,
4. Химийн бодисын хадгалалтын явцад асгарч алдагдсан тохиолдолд хортой аюултай хий ялгарах

### Жилийн туршид тогтмол хийн гүйцэтгэсэн ажлууд:

1. Үйлдвэрийн гадна орчныг хаврын улиралд тохижуулан зүлэгжүүлж, тогтмол цэвэрлэгээ арчилгааг хийсэн. Мөн дулааны улиралуудад саарал усаар мод, ногоон байгууламж болон ойр орчмыг услан цэвэр усны шууд хэрэглээг багасгаж түүнчлэн орчны тоосжилт үүсэхээс сэргийлэв.
2. Техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянан ханган ажиллаж хүрээнд Түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний тээвэрлэлтэнд ашиглах машинг жил бүрийн тогтмол техникийн үзлэг оношилгоонд оруулан, агаар бохирдуулсаны төлбөрийг төлсөн. Нийт оншилгоонд 50 орчим тээвэрийн хэрэгслийг хамруулж үүнээс 15 гаруй том оворын тээврийн хэрэгслүүд Захиргааны зориулалтын 30-н суудлын машинг оншилгоод хамруулсан байна.
3. Химийн бодисын агуулахын өргөтгөлийг хийн гүйцэтгэж агуулах дотор болон гадна хяналтын камер болон хий илрүүлэгч суурин багаж байршуулахаар төлөвлөсөн байна.



Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

**Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

1. Үйлдвэрийн хаягдал ус нь стандартын шаардлага хангахгүй байх
2. Төслийн хүрээнд усны нөөц ашиглах, хомсдох

**Төлөвлөгөөний гүйцэтгэл:** Өөрийн лабораторит сар бүр үйлдвэрийн хаягдал бохир усны шинжилгээг хийн гүйцэтгэж хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэрлэсэн бохир усны техникийн шаардлага MNS 4943 : 2015 стандартын үзүүлэлтүүдийг тогтмол хянаж байна. Мөн улирал бүр Ус сувгийн удирдах газрын лабораторит бохир усны дээжийг шинжлүүлэн баталгаажуулу тогтмол хяналтандаа байлгаж байна.

Усны нөөцийг хэмнэх, дахин ашигласан усны хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд үйлдвэрийн цех бүрийн усны хэрэглээг нарийвчлан тооцон анализ хийж, тоног төхөөрөмж, шугам хоолойн алдагдлыг олж тодорхойлон инженерийн болон техникийн аргачилалаар шийдвэрлэн сайжруулах, шинэчлэх арга хэмжээүүдийг авч нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны нормыг хамгийн боломжит бага хэмжээнд хүргэж өмнөх онтой харьцуулахад 20 гаруй хувиар усны хэрэглээгээ буурууллаа. Доор жишээ хийгдсэн ажлуудын харуулав.

*Спиртийн үйлдвэр: Исгэлт, нэрлэг, хөргөлтийн хэсэгт саарал ус ашиглах цэг нэмж цэвэрлэгээнд ашиглаж байна.*



*Тээвэр түгээлтийн хэсэг: Ложистикийн хэсгийн ачилтын машин угаах цэгийг үйлдвэрээс хаягдаж буй саарал усаар хангаж байна.*



Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

**Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

1. Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдал ил задгай үүсэх, хаягдлыг зайлуулалгүй удааснаар хөрс бохирдох
2. Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх, зөөгдөх

**Жилийн туршид тогтмол хийн гүйцэтгэсэн ажлууд:**

Тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдлын үйлчилгээ үзүүлэх, дахин боловсруулах устгах үйл ажиллагаатай байгууллагуудтай гэрээ хэлэлцээрийн дагуу ажиллаж үүссэн болон цугларсан хатуу ба аюултай хог хаягдлыг тухай бүр ачуулан дахин боловсруулах болон устган зайлуулах арга хэмжээ рүү шилжүүлж байна. Хог хаягдлын төвлөрсөн цэгт ангилан ялгалтын дагуу хуримтлуулж холбогдох компаниуд руу нийлүүлдэг ба тогмол цэвэрлэгээ үйлчилгээ хийгддэг тул хөрсөн давхаргад нөлөөлөх шууд сөрөг нөлөөгүй. Үйлдвэрийн нийт ногоон байгууламж бүхий талбайг тогтмол тордон арчлан, усладаг. Машин техникийг тогтоосон тээврийн хэрэгслийн зам талбайгаар зоричуулдаг.

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

**Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

**Төлөвлөгөөний гүйцэтгэл:**

1. Үйлдвэрийн гадна орчинд жил бүр мод суулгацыг шинэчлэж зүлэгжүүлдэг.
2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн амжилттай

оролцож 1200 ширхэг нарс модыг тарив.




Зураг 5. Үйлдвэр орчмын ногоон байгууламж

Цахилгаан эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Байгалийн нөөцийн хомсдол үүсэх

2022 онд цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулах зорилтын хүрээнд эрчим хүчний баг байгуулагдан эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөр болон эрчим хүчний аудитыг мэргэжлийн байгууллага болон “Дулаан техникийн шинэчлэлийн төв” ХХК амжилттай аудит хийлгэж тайланг гаргуулсан. Энэхүү ажлын хүрээнд уур ус, дулааны алдагдлыг тодорхойлох аудитуудыг үйлдвэрийн нэгж хэсгүүдэд хэсэгчилэн 2022 оны 9-р сараас хойш хийн гүйцэтгэлээ. Аудитын дараа үйлдвэр нэгж хэсгүүд үл тохиролын залруулгуудыг хийн гүйцэтгэж энэргийн алдагдлыг арилгаж хэрэглээний хэмнэлтийг хийж байна. Мөн уур, ус, дулаан, цахилгааны зарцуулалт үйлдвэр хэсэг бүрээр тодорхойлон хянаж, их хэрэглээтэй нэгж хэсэг болон тоног төхөөрөмжийн хэрэглээг бууруулах, сайжруулах арга хэмжээнүүдийг авч хэрэглэлээ. Доор жишээ хийгдсэн ажлуудын харуулав.



Эрчим хүчний аудитын хүрээнд үйлдвэр нэгж хэсгүүдэд нийт 10 орчим аудитыг хийн үйлдвэрүүд залруулах арга хэмжээг авч сайжруулж байна. Өмнөх оны энэ үетэй харьцуулахад дулааны хэрэглээ 17.3%, цахилгааны хэрэглээ 8.4% -иар тус тус буурсан байна.

Ажлын үйл ажиллагааны нэр	Туслах үйлчилгээний үйлчилгээний нэр	Туслах үйлчилгээний үйлчилгээний нэр	Туслах үйлчилгээний үйлчилгээний нэр	Туслах үйлчилгээний үйлчилгээний нэр	Туслах үйлчилгээний үйлчилгээний нэр
1	1.1	1.1.1	1.1.1.1	1.1.1.1.1	1.1.1.1.1.1
2	2.1	2.1.1	2.1.1.1	2.1.1.1.1	2.1.1.1.1.1
3	3.1	3.1.1	3.1.1.1	3.1.1.1.1	3.1.1.1.1.1
4	4.1	4.1.1	4.1.1.1	4.1.1.1.1	4.1.1.1.1.1
5	5.1	5.1.1	5.1.1.1	5.1.1.1.1	5.1.1.1.1.1
6	6.1	6.1.1	6.1.1.1	6.1.1.1.1	6.1.1.1.1.1
7	7.1	7.1.1	7.1.1.1	7.1.1.1.1	7.1.1.1.1.1
8	8.1	8.1.1	8.1.1.1	8.1.1.1.1	8.1.1.1.1.1
9	9.1	9.1.1	9.1.1.1	9.1.1.1.1	9.1.1.1.1.1
10	10.1	10.1.1	10.1.1.1	10.1.1.1.1	10.1.1.1.1.1
11	11.1	11.1.1	11.1.1.1	11.1.1.1.1	11.1.1.1.1.1
12	12.1	12.1.1	12.1.1.1	12.1.1.1.1	12.1.1.1.1.1
13	13.1	13.1.1	13.1.1.1	13.1.1.1.1	13.1.1.1.1.1
14	14.1	14.1.1	14.1.1.1	14.1.1.1.1	14.1.1.1.1.1
15	15.1	15.1.1	15.1.1.1	15.1.1.1.1	15.1.1.1.1.1
16	16.1	16.1.1	16.1.1.1	16.1.1.1.1	16.1.1.1.1.1
17	17.1	17.1.1	17.1.1.1	17.1.1.1.1	17.1.1.1.1.1
18	18.1	18.1.1	18.1.1.1	18.1.1.1.1	18.1.1.1.1.1
19	19.1	19.1.1	19.1.1.1	19.1.1.1.1	19.1.1.1.1.1
20	20.1	20.1.1	20.1.1.1	20.1.1.1.1	20.1.1.1.1.1

Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж үйлдвэр нээж хэсгүүдийн ажилд, технологич инженерүүд гүйцэтгэлийг биелүүлэн ажиллаж байна. Төлөвлөн хэрэгжүүлсэн ажилаас дурдвал Шар айрагийн үйлдвэр 2-н халуун усны бойлурын өмнө конденсацйн усыг дахин ашиглаж урдчилсан халаалт явуулах систем шинээр татах, Спиртийн исгэлтийн CO2 угаасан усныг шахах насосыг автоматжуулах, Архи найрах цехэд бага оврын хийн компрессор авах, Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн өөрчлөлт, шинэчлэлтийг стандаржуулах гэх мэт ажлуудыг хийжээ.



Үйлдвэрийн цех хэсгийн гэрэлтүүлэгийг лед гэрлээр сольж тавьсан, мөн хөдөлгөөн мэдрэгчтэй гэрэл суурилуулсан.

### 3.3 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Химийн бодисын хадгалалтад Монгол Улсын хууль, дүрэм журмууд болон компанийн дотоод журам болох химийн бодисын хяналтын тухай журмын дагуу хяналт тавин ажиллаж байна. Компанийн хэмжээнд нийт 233 нэр төрлийн химийн бодисыг төв лаборатори болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглаж байна. Үйлдвэрийн технологи болон тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглах бодисуудыг “Soruga” олон улсын компанийн бодисыг хэрэглэдэг ба лабораторийн хэрэгцээний химийн бодисуудыг дотоодын компаниудаас худалдан авдаг. Бодисуудын сав, баглаа боодол бүрэн бүтэн эсэхийг шалган тээвэрлэх бөгөөд бодисууд нь хоруу чанар багатай, тогтвортой шинж чанартай. Хадгалалтын хувьд химийн бодисуудыг “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. “MNS 6458:2014”- ийн шаардлага хангасан агуулахад хадгалах журмын дагуу ангилан, нэр хаяг, шошго, анхааруулах үг, тэмдэг тэмдэглэгээ, хор аюулын мэдээллийг байршуулан хадгалах тул санамсаргүй осол, эрсдлээс бусад тохиолдолд сөрөг нөлөө бага. Үйлдвэр үйл ажиллагааны хүрээнд ашиглаж буй бүх химийн бодисыг ХАЛМ-тай байлгаж бүртгэлжүүлэн ажиллаж байна. Бодисууд нь 25-200кг болон 20-200л-ийн хэмжээ шуудай, хуванцар савлагаатай.

№	Төлөвлөгдсөн ажил	Биелэлт
<b>Тээвэрлэх</b>		
1	Тээвэрлэлт хийж буй жолооч нарыг сургалтанд хамруулж, химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг олгох	Химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны талаарх сургалтанд хамрагдсан гэрээт компаний ажилчид тээвэрлэлтэд ажилладаг ба холбогдох үйлдвэрийн ажилчид химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалт болон АПУ ХК -ийн дотоодод мөрдөгдөх шинэчлэгдсэн химийн бодисын хяналтын тухай журмын танилцуулах сургалтанд хамрагдсан.
2	Химийн бодисыг тээвэрлэхдээ сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг ханадаг байх, асгарч алдагдсан тохиолдолд хураан авах саармагжуулах, хоргүйжүүлэх материал, гал унтраах багаж хэрэгслээр тээврийн хэрэгслийг тоноглох	Тээвэрлэлтийн гэрээт компаниудад Химийн бодисыг тээвэрлэхдээ сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг ханадаг байх, асгарч алдагдсан тохиолдолд хураан авах саармагжуулах, хоргүйжүүлэх материал, гал унтраах багаж хэрэгслээр тээврийн хэрэгслийг тоноглох шаардлагыг тавин ажилладаг.
<b>Хадгалах</b>		
3	Химийн бодисуудыг битүүмжлэл сайтай хуурай, сэрүүн, агааржуулалт сайтай агуулахад бодисын хор аюулын мэдээлэлд заасны дагуу хадгалах	Химийн бодисын шинэ агуулахыг барин ашиглалтанд оруулсан ба агуулахад бодисын хор аюулын мэдээлэлд заасны дагуу химийн бодисууд хадгалагдаж байна.
4	Химийн бодисын агуулахыг стандартын дагуу тохижуулах, агуулахыг орчим ил гал гаргах, тамхи татахгүй байх	Шинэ химийн бодисын агуулахын стандартын дагуу тохижуулалт хийгдэж байгаа ба агуулахын орчим ил гал гаргах эрсдлээс сэргийлсэн галын дохиолол болон яаралтай үеийн галын аюулгүй байдлын тусламж байрлуулсан. Мөн зөвшөөрөгдсөн тамхи татах цэг агуулахын ойр орчим байрладаггүй.



5	Химийн бодис асгарч, алдагдах, ажиллагсад хордох, бэртэх, гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл бэлэн байлгах	Химийн бодисын агуулахад химийн бодис асгарч, алдагдах, ажиллагсад хордох, бэртэх, гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл бүрэн байршуулагдсан.
6	Болзошгүй эрсдэл тохиолдсон үед эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдлийн сан үүсгэх, байнгын бэлэн байдалд байлгах	Компаний дотоод онцгой байдалд бэлэн байх, хариу арга хэмжээ авах журмаар зохицуулагдан байнгын бэлэн байдлыг ханган ажилладаг.
<b>Эрсдэлд тохиолдсон үед авах арга хэмжээ</b>		
7	Гал гарсан тохиолдолд гал унтраагуур, гал түймрийн голомтод ажиллагсдыг бүх биеийг хамгаалах хувцас, хэрэглэл, бээлий, хорт утааны багтай ажиллах нөхцлөөр хангах	Галын аюулын сан нь гал унтраагуур, гал аюулын хамгаалах хувцас, хэрэглэл, бээлий, хорт утааны баг зэргийг бэлтгэн байрлуулсан.
8	Химийн бодис асгарсан тохиолдолд химийн бодис хадгалах, зориулалтын саванд цуглуулах, шингээгч материал ашиглах, асгарсан талбайг сайтар цэвэрлэх, агааржуулах	Химийн бодисын агуулахад гэнэтийн үед химийн бодис асгарсан тохиолдолд химийн бодис цуглуулах, хадгалах зориулалтын сав, шингээгч материал зэргийг ханган байрлуулсан.
9	Нүд, арьс салст, амьсгал болон залгисан тохиолдолд зааврын дагуу арга хэмжээ авах, эмнэлгийн анхан тусламж үзүүлэх	Химийн бодисын агуулахад яаралтай үед хэрэглэх эмнэлгийн анхан тусламжийн сан болон нүдний зайлуур болон шүршүүр байршуулагдсан.



10	Ноцтой ослын үед аюулын бүс тогтоох, энэ талаар мэргэжлийн байгууллага (ОБЕГ, МХЕГ)-д нэн даруй мэдэгдэж орчны хяналт шинжилгээний талаар дүгнэлт гаргуулах, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах	ОБЕГ -ын гэнэтийн аюул ослын сургалтанд ажилчдыг хамруулдаг ба ноцтой аюул ослын үед хамтран ажиллахад бүрэн бэлтгэлтэй байдаг.
----	--	---

### 3.4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

АПУ ХК нь хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж байна. Хог хаягдлын 3R стратегийг үйлдвэр нэгж хэсгүүдэд хэрэгжүүлэн хог хаягдлын цэгүүдийг 5S зарчмын дагуу сайжруулан хог хаягдлын ангилан хаялтыг нэмэгдүүлж байна. Хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах хүрээнд Шинэ Шил ХХК, Мультипак ХХК, Эко Орчин ХХК, Түмэн эгшиг ХХК-т хамтран ажиллаа. Энэ хүрээнд үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг өмнөх онтой харьцуулахад 30%-аар бууруулж, хаягдал шилийг боловсруулах үйлдвэр Шинэ Шил ХХК-д хаягдал гялгар уутыг Мультипак ХХК-д тус тус нийлүүлэн нүхэн жорлонгийн доторлогоо, барилгын дулаалгын хөөс хийхэд зориуллаа. Мөн үйлдвэрлэлээс гарч органик хог хаягдал болох улаан буудайн, арвайн соёолжийн үлдэгдлийг малчид фермерүүдэд хөрөнгө шаарыг малын тэжээлийн үйлдвэрт тогтол нийлүүлсээр байна.




Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжийг бүрдүүлэн, хогийн савнуудын хаягжилтыг шинэчлэн, үйлдвэр бүрт бүртгэлжүүлэн, төвлөрсөн хогийн цэгийг сайжруулсан. Мөн оффисын хог хаягдлыг ангилан ялгах боломжийг сайжруулан, хогийн савнуудыг стандартад

нийцүүлэн шинэчлэн байрлуулсан. Үйлдвэр болон оффисын орчинд хог хаягдлыг дахивар, цаас, ахуйн болон аюултай хог хаягдал гэсэн 4 бүлэгт хуваан хог хаягдлыг ангилаж байна. Төвлөрсөн хогийн цэгээс энгийн хог хаягдлыг Эко орчин ХХК тээвэрлэн, дахин боловсруулах дахин ашиглах аж ахуйн нэгж хувь хүн байгууллагууд руу нийлүүлдэг. Дахин боловсруулагдахгүй хог хаягдлыг морингийн даваан хог хаягдлыг төв цэгт аваачдаг.



Зураг 7. Ангилан ялгалтын хогийн савнууд \оффис болон үйлдвэрийн хэсэг




Зураг 5. Ангилан ялгалтын хогийн савнууд \оффис болон үйлдвэрийн хэсэг

Бид хаягдал шилээ дахин ашиглах зорилгоор Шинэ Шил ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу одоогийн байдлаар 400 орчим тонн шилийг нийлүүлсээр байна. Хөөсөн шил үйлдвэрлэх туршилтыг анхлан явуулахад АПУ компанианаас гарч байгаа хаягдал шилний цахиур түүхий эдийн шаардлагыг бүрэн хангаж байсан тул ийнхүү эдийн засгийн эргэлтэнд

оруулж эхэллээ. Хөөсөн шил нь импортыг орлох бүтээгдэхүүн бөгөөд галд тэсвэртэй, цантахгүй, бат бөх, амархан зүсэгддэг зэрэг олон давуу талтай.



Үйлдвэрлэлээс гарах шингэн хаягдлын хувьд органик хог хаягдал болох улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдэл, шар айраг шүүлтүүрийн материал кизелгүр гардаг. Улаан буудай, арвайн соёолж, хөрөнгийн үлдэгдлийг малчид фермерүүдэд, хаягдал хөрөнгө, шаарыг тэжээлийн үйлдвэр “Баялаг фийд” ХХК -д тогтмол гэрээ байгуулж нийлүүлж малын тэжээл уураг хийдэг.




Зураг 6. Прессэрийн дараах KG

Харин шар айргийн шүүлтүүрийн материал болох кизельгүүр зэрэг гардаг ба дахин ашиглалтыг онцгой анхаарч ажиллаж байна. Тухайлбал өмнө нь бид шар айргийн шүүлтийн процесст оролцдог Кизельгургыг хаягдал усны шугамд хаядаг байсан бол одоо шүүх хатаах төхөөрөмж суурилуулан хатуу хог хаягдал болгон ашиглаж байна. Кизельгур нь байгалийн нэгдэл бөгөөд агрохими хүнд металлын шинжилгээгээр стандартын шаардлага хангадаг учир газар тариалангийн салбар болон зам барилгын салбарт бүрэн ашиглах боломжтой гэдэг эрдэм шинжилгээний судалгаан дээр үндэслэн судалгааны ажлыг “Ойм ногоон урлан ХХК” -тай хамтран эхлүүлсэн. Үйлдвэрлэлээс гарч байгаа нийт хог хаягдлын 9.8% хувийг эзэлдэг

Кизельгурийн эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг бид ийнхүү судалсаар байна. Үүний хамгийн том ач холбогдол нь уур амьсгалын өөрчлөлт, хөрсний доройтол, цөлжилтийг бууруулах гадна хогийн цэгт очих хаягдлыг бууруулах үр нөлөөтэй юм.



Аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодол, зайг дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны үйлдвэр Түмэн Эгшиг ХХК, эмнэлгийн аюултай хог хаягдлыг Элемент Мэдикал ХХК -д тус тус нийлүүлж байна.

Хадгалалтын хувьд хог хаягдлын төвлөрсөн цэгт тусдаа аюулгүй байдлыг нь ханган хадгалдаг. Хаягдал химийн бодисын сав баглаа боодлын нэр хаяг, шошго, анхааруулах үг, тэмдэг тэмдэглэгээ, хор аюулын мэдээллийг байршуулан хадгалан санамсаргүй осол, эрсдлээс урьдчилан сэргийлэн ажилладаг.



Зураг 8 . Аюултай хог хаягдлын сав баглаа боодлын ачилт

**3.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

№	Орчны хяналт шинжилгээний төрөл	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Агаар	Агаарын чанар- NO2, SO2, нийт тоосны агууламж	Нийт 4 цэгт: Үйлдвэрийн гадна ба дотор орчин -Үйлдвэрийн урд болон хойд хэсэгт, Агуулахуудын дотор хэсэгт	Жилд нэг удаа	65,000	869,000	Ногоон Титэм ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ажлын байрны орчин зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Дуу чимээ	Дуу чимээ - Дотоод орчны дуу шуугианы түвшин	Нийт 6 цэгт: Үйлдвэрийн цехүүдэд (Нэрийн архи савлах, ус ундаа савлах, найрлага бэлдэх, пиво савлах, архи савлах цех)	Жилд нэг удаа	10,000	60,000	Байгаль орчны Хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн.	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
3	Ус	Төвлөрсөн ус хангамжийн усны чанарын шинжилгээ	Үйлдвэр тус бүрийн авч буй ус /12/	Сар бүр	800,000	9,600,000	АПУ төв лабораторид шинжлүүлсэн.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.

4	Бохир ус	Нийлүүлэх хаягдал усны шинжилгээ	Ариутгах татуургын шугамд орохын өмнөх хэсгээс эсвэл үйлдвэр тус бүрийн хаягдал ус гаргах хэсгээс	Улирал бүр	1,200,000	9,600,000	АПУ төв лабораторид шинжлэнэ. Мөн УСУГ -ын төв лабораторид жилд нэг удаа шинжлүүлсэн.	MNS6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усанд тавигдах ерөнхий шаардлага
5	Хөрс	Хөрсний чанар - Хүнд металлууд	Нийт 4 цэгт: 1. Хог хаягдлын цэгийн орчимд, 2. Үйлдвэрийн ногоон байгууламж орчим, 3. Ауруг авто зогсоолын орчим, 4. Агуулахын байр орчим	Жилд нэг удаа	25,000	150,000	Эрдэс судлалын Хан Лаб лабораторид шинжлүүлсэн.	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ



